



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

"Сэлэнгэ Энерго" ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/16/-НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn
Сүхбаатар сум 2024 он	Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn Аудитор: Ц.Уртнасан Утас: 7036-3047 Цахим хаяг: Urtaa6969@gmail.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЭХЗХ	Эрчим хүчний зохицуулах зөвлөл

Агуулга

1.Аудитын дүгнэлт	3-4
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	10
3.Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.1 Байгууллагын үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	12
3.5. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	14
3.6. Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	14
4. Аудитын тайлан	15
4.1. Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал.....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны мэдээлэл	16
4.5. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 ЗАВСРЫН АУДИТЫН ТАЛААР.....	17
4.5.2 ӨМНӨХ АУДИТЫН МӨРӨӨР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮР ДҮН	17
4.6. Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. Аудитын илрүүлэлт	17
5.1 Төлбөрийн акт	18
5.2 Албан шаардлага	18
5.3 Зөвлөмж.....	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	20



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.03.15 № СЭА-2024/16-НН-СТА-ОНА
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан зөрчлийн нөлөөг эс тооцвол “Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон 86,540.5 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь заалтууд болон аймгийн Засаг даргын баталсан 2023 оны “Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг”-тэй тус тус нийцээгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

“Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ нь аймгийн ОНӨГ-ын шийдвэрийн дагуу тайлант онд үндсэн хөрөнгийн барилга, байгууламжийн дахин үнэлгээг Сор үнэлэмж ХХК-иар хийлгэснээр үндсэн хөрөнгө 6,539,249.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Аудитын гол асуудал

Нийгмийн даатгалын шимтгэлийн 2,141,315.7 мянган төгрөгийн өр төлбөрийг барагдуулаагүйгээс нийгмийн даатгалын сангаас олговол зохих 28,186.4 мянган төгрөгийн ХЧТА тэтгэмж, 6,601.2 мянган төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж, 4,727.8 мянган төгрөгийн

жирэмсний болон амаржсаны тэтгэмж зэрэг нийт 39,515.4 мянган төгрөгийг Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.6 дахь “Ажил олгогчийн буруугаас даатгуулагчид учирсан хохирлыг бүрэн хариуцаж төлөх” гэсэн заалтын дагуу үйлдвэрийн газраас төлсөн нь алдагдлын хэмжээнд нөлөөлж байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

“Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ-ын 2023 оны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 8 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	10,561,149.98	6,585,632.36
1.1.2	Дансны авлага	1,440,804,033.83	1,455,246,168.51
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага		56,609.59
1.1.4	Бусад авлага	-	4,291,712.00
1.1.6	Бараа материал	802,886,888.88	875,108,380.39
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	2,254,252,072.69	2,341,288,502.85
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	20,414,635,666.55	13,717,349,048.35
1.2.2	Биет бус хөрөнгө		14,010,000.00
1.2.3	Бусад эргэлийн хөрөнгө	568,520,400.00	568,520,400.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	20,983,156,066.55	14,299,879,448.35
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	23,237,408,139.24	16,641,167,951.20
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	3,513,741,633.41	3,766,684,477.31
2.1.1.2	цалингийн өглөг	108,798,955.00	151,852,787.00
2.1.1.3	Татварын өр	2,156,803,314.78	3,084,713,057.42
2.1.1.4	НДШ - ийн өглөг	1,730,006,548.68	2141315703
2.1.1.5	Богино хугацаат зээл	57,022,746.48	
2.1.1.10	хүүний өглөг		43,294,124.23
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	7,566,373,198.35	9,187,860,148.68
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	265,291,438.84	161,737,822.43
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	265,291,438.84	161,737,822.43
2.2	Өр төлбөрийн нийт дүн	7,831,664,637.19	9,349,597,971.11
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: -төрийн	10,947,818,680.48	11,576,804,189.48
2.3.2	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	15,455,050,972.96	8,736,940,966.15
2.3.4	Хуримтлагдсан ашиг	(10,997,126,151.39)	(13,022,175,175.54)
2.3.11	Эздийн өмчийн дүн	15,405,743,502.05	7,291,569,980.09
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	23,237,408,139.24	16,641,167,951.20

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/Төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	5,674,443,434.69	5,445,254,653.48
2	Борлуулалтын өртөг	7,937,777,243.05	8,529,670,307.44
3	Нийт ашиг (алдагдал)	(2,263,333,808.36)	(3,084,415,653.96)
5	Бусад орлого	2,067,916,382.14	2,208,863,239.68
6	Хүүгийн орлого		120,515.97
7	Эрхийн шимтгэлийн орлого		28,363,636.08
8	Ерөнхий ба удирдлагын зардал	612,060,753.92	599,426,020.04
9	Санхүүгийн зардал	3,593,855.02	
10	Бусад зардал	100,625,254.08	
11	Бусад ашиг (алдагдал)	-	2,872,431.00
12	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(911,697,289.24)	(1,443,621,851.27)
13	Орлогын татварын зардал		
14	Татварын дараах ашиг (алдагдал)	(911,697,289.24)	(1,443,621,851.27)
15	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
16	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(911,697,289.24)	(1,443,621,851.27)
18	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	10,947,818,680.48	15,455,050,972.96	(10,997,126,151.39)	15,405,743,502.05
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				-
Залруулсан үлдэгдэл	10,947,818,680.48	15,455,050,972.96	(10,997,126,151.39)	15,405,743,502.05
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(911,697,289.24)	
2022 оны 12 - р сарын 31 - ний үлдэгдэл	10,947,818,680.48	15,455,050,972.96	(10,997,126,151.39)	15,405,743,502.05
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			(581,427,172.88)	(581,427,172.88)
Залруулсан үлдэгдэл	10,947,818,680.48	15,455,050,972.96	(11,578,553,324.27)	14,824,316,329.17
Өмчид гарсан өөрчлөлт	628,985,509.00			628,985,509.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		(6,718,110,006.81)		(6,718,110,006.81)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(1,443,621,851.27)	(1,443,621,851.27)
2023 оны 12 - р сарын 31 - ний үлдэгдэл	11,576,804,189.48	8,736,940,966.15	(13,022,175,175.54)	7,291,569,980.09

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	2022.12.31	2023.12.31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	7,212,917,378.56	7,898,782,222.21
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	5,777,557,928.56	5,452,294,521.21
	Эрхийн шимтгэл, хураамж төлбөрийн орлого	-	31,200,000.00
	Татаас, санхүүжилтийн орлого	1,400,000,000.00	2,393,861,300.00
	Бусад мөнгөн орлого	35,359,450.00	21,426,401.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	7,338,337,771.17	7,721,255,039.39
	Ажиллагчдад төлсөн	2,303,477,812.00	2,044,311,739.01
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	98,989,717.73	111,714,127.00
	Бараа материал худалдан авахад төлсөн	1,862,010,201.00	2,648,969,455.00
	Бичиг хэргийн зардал	9,480,400.00	
	Ашиглалтын зардалд төлсөн	1,325,614,501.00	973,949,860.63
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,475,827,225.94	1,513,073,008.90
	Хүүний төлбөрт төлсөн	74,643,983.49	62,808,849.17
	Татварын байгууллагад төлсөн	92,988,337.79	227,342,159.68
	Даатгалын төлбөрт төлсөн	2,108,800.00	2,299,575.00
	Бусад мөнгөн зарлага	93,196,792.22	136,786,265.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-125,420,392.61	177,527,182.82
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	34,079,600.00	77,513,600.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	34,079,600.00	60,983,600.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		16,530,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(34,079,600.00)	(77,513,600.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	300,000,000.00	33,120,515.97
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	300,000,000.00	33,000,000.00
	Хүүгийн орлого		120,515.97
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	144,315,024.13	137,109,616.41
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	144,315,024.13	136,553,616.41

3.2.2	бусад		556,000.00
3.2	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	155,684,975.87	(103,989,100.44)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	<u>(3,815,016.74)</u>	<u>(3,975,517.62)</u>
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	14,376,166.72	10,561,149.98
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	10,561,149.98	6,585,632.36

2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 оны		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Борлуулалтын орлого	м/төг	6,198,404.0	5,449,129.0	749,275.0	12.1
2	Бусад орлого	м/төг	40,357.0	58,175.0	(17,818.0)	44.2
3	Орон нутгийн татаас	м/төг	1,800,000.0	2,182,043.0	(382,043.0)	21.2
2	Нийт орлого	м/төг	8,038,761.0	7,689,347.0	349,414.0	4.3
3	Нийт зардал	м/төг	9,573,390.0	9,129,390.0	30,627.0	4.6
	Үүнээс: Удирдлагын зардал	м/төг	147,534.0	116,907.0	30,627.0	20.8
4	Татварын өмнөх ашиг	м/төг	(1,534,629.0)	(1,440,043.0)	318,787.0	6.2
5	Цэвэр ашиг /алдагдал /	м/төг	(1,534,629.0)	(1,440,043.0)	318,787.0	6.2
6	Төсвийн төлбөр	м/төг	1,197,744.0	1,813,305.0	(615,561.0)	51.4
	а/Орлогын татвар	м/төг			-	
	б/НӨАТ	м/төг	619,840.0	1,419,875.0	(800,035.0)	129.1
	в/НДШ	м/төг	350,717.0	348,546.0	2,171.0	0.6
	г/ХАОАТ	м/төг	207,018.0	29,752.0	177,266.0	85.6
	д/ҮХЭХАТ	м/төг	13,704.0	9,255.0	4,449.0	32.5
	е/Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	м/төг	665.0	480.0	185.0	27.8
	ё/Бусад татвар	м/төг	5,800.0	5,397.0	403.0	6.9
7	Нийт ажиллагсдын тоо	Хүн	127.0	119.0	8.0	6.3
8	Нийт цалингийн сан	м/төг	2,418,734.0	2,413,619.0	5,115.0	0.2
9	Нэг ажиллагчийн дундаж цалин	м/төг	1,587.1	1,690.2	(103.1)	6.5
10	Борлуулалтын орлогын 1 төг ногдох зардал	м/төг	1.5	1.7	(0.1)	9.1
11	Хөрөнгө оруулалт	м/төг	649,255.0	509,979.6	139,275.4	21.5
12	Нийт авлага	м/төг	1,140,802.1	1,459,537.0	(318,734.9)	27.9
	Үүнээс: найдваргүй	м/төг			-	
13	Нийт өглөг	м/төг	7,831,664.0	9,349,597.0	(1,517,933.0)	19.4
	Богино хугацаат өглөг	м/төг	7,669,127.0	9,187,860.0	(1,518,733.0)	19.8
	Урт хугацаат өглөг	м/төг	162,537.0	161,737.0	800.0	0.5

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

“Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ нь *“Байгаль орчинд ээлтэй, хэмнэлттэй үр ашигтай технологи ашиглан хэрэглэгчдийн тав тухтай ажиллаж, амьдрах орчныг бүрдүүлж дулааны эрчим хүчээр жигд тасралтгүй найдвартай ханган ажиллах”* гэсэн үндсэн чиг үүрэгтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

“Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ-ын дүрэмд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Дулааны эрчим хүч үйлдвэрлэх, борлуулах,
- Гадаад дотоод худалдаа,
- Туслах үйлдвэрлэл хөгжүүлэх,
- Гуанз цайны газрын үйлчилгээ,

Тус ОНӨААТҮГ нь 2023 онд ЭХЗХ-ны *“Дулаан үйлдвэрлэх, дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах зөвшөөрлийн үйлчлэх”* хүрээнд Сүхбаатар суманд КЕВ-25/14 маркийн 2 зуухаар, КВТС-20/150 маркийн 1 зуухаар дулааныг үйлдвэрлэн дулаан түгээж, жилд 29.2 мян.тн нүүрс, 2.65 сая.квт/ц цахилгаан эрчим хүч, 43.1 мян.м ус хэрэглэж, 59.7 мян.Гкал дулаан үйлдвэрлэж, нийт 346 албан байгууллага, ААН, 50 төсвийн байгууллага, 2,995 айл өрхөд 55.0 мян.Гкал дулааны эрчим хүч түгээсэн байна.

Тайлант онд дулаан хэрэглэгч 1,251 амины сууцанд амьдардаг айл өрхөөс 450 айл өрхийн талбайн хэмжилтийг дахин хийж, 2,030м³ талбайн зөрчил, 346 аж ахуйн нэгж, байгууллагаас 46 аж ахуйн нэгж, байгууллагын талбайн хэмжилтийг дахин хийж 9,104м³ талбайн зөрчлийг тус тус илрүүлсэн байна.

Улсын бүртгэлийн гэрчилгээнд Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэсэн статустай бүртгэгдсэн бөгөөд үйлдвэрийн газрын үүсгэн байгуулагч нь Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, 100 хувь орон нутгийн өмчтэй аж ахуйн нэгж юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

“Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ нь аймгийн ИТХ-ын 2002 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 60 дугаар тогтоолоор байгуулагдсан байна. Энэ нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь *“Аймаг, сум, нийслэл, дүүрэг нь хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулж болно.”*, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх *“Аймгийн чиг үүрэгт дараах асуудал хамаарна:”, 21.1.15 дахь “харилцаа холбоо, цахилгаан, дулаан түгээх сүлжээ, цэвэр ус, бохир усны шугам болон хаягдал ус зайлуулах байгууламж, үерийн далан, суваг тэдгээрт хамааралтай барилга байгууламжийн төлөвлөлт, ашиглалт, хяналт”* Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2 дахь *“Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхтэй:...* 4/ **Орон нутгийн өмчийн хуулийн**

этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих” гэсэн заалттай нийцэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд өөрчлөлт орсон гэх мэт.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц гэж үнэлсэн.

“Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ” нь 2021 онд боловсруулагдсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

“Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Нийт хөрөнгө өмнөх оноос 6,683,276.6 мянган төгрөгөөр буурсан нь мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр дансанд материаллаг өөрчлөлт гарснаас шалтгаалсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	10,561.10	6,585.60	(3,975.50)
Авлага	1,440,804.00	1,459,594.50	18,790.50
Бараа материал	802,886.90	875,108.40	72,221.50
Үндсэн хөрөнгө	20,983,156.10	14,299,879.40	(6,683,276.70)
Нийт хөрөнгийн дүн	23,237,408.10	16,641,167.90	(6,596,240.20)
Өр төлбөр	7,831,664.60	9,349,597.90	1,517,933.30
Эздийн өмч	15,405,743.50	7,291,570.00	(8,114,173.50)

Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	23,237,408.10	16,641,167.90	(6,596,240.20)
--	---------------	---------------	----------------

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Авлагын дансны үлдэгдэл 18,790.5 мянган төгрөгөөр өсч, 1,459,594.50 мянган төгрөгөөр тайлагнагдсан нь ААНБ-ын дулааны авлага өссөнөөс шалтгаалсан байна. Нийт авлагын 65.4 хувийг буюу 953,811.9 мянган төгрөгийг төсөвт байгууллагын, 21.7 хувийг буюу 317,508.5 мянган төгрөгийг аж ахуйн нэгж байгууллагын, 9.2 хувийг буюу 133,590.3 мянган төгрөгийг төвлөрсөн орон сууцны айд өрхийн, 1.7 хувийг буюу 25,052.5 мянган төгрөгийг хувийн орон сууцны айл өрхийн, 2.0 хувийг буюу 29,631.3 мянган төгрөгийг бусад авлага тус тус эзэлж байна.
- Бараа материал дансны үлдэгдэл 72,221.5 мянган төгрөгөөр өссөн нь 2,949,838.1 мянган төгрөгийн бараа материал нэмэгдэж, 2,877,616.6 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас шалтгаалсан байна. Бараа материалын үлдэгдэлд ашиглалтгүй их хэмжээний нөөц үүсгээгүй байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 6,683,276.7 мянган төгрөгөөр буурсан нь дараах ажил, гүйлгээнээс шалтгаалсан байна. Үүнд:
 - Өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр 79,693.5 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан,
 - Аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 98,985.5 мянган төгрөгийн инженерийн шугам сүлжээний засварын ажил, 50,000.0 мянган төгрөгийн дээврийн засварын ажил хийгдэж капиталжуулсан, 298,000.0 мянган төгрөгийн усан шахуургын насос, аймгийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн, 182,000.0 мянган төгрөгийн авто түгээгч бульдозер үнэ төлбөргүй хүлээн авсан,
 - Аймгийн ИТХ-ын 2023 оны 123 дугаар тогтоолоор 35,000.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 124 дүгээр тогтоолоор 171,910.4 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил акталж дансаас хассан,
 - Барилга байгууламжид 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар “Сор үнэлэмж” ХХК-иар дахин үнэлгээ хийлгэж 6,539,249.3 мянган төгрөгөөр бууруулсан,
 - Тайлант онд 645,796.0 мянган төгрөгийн элэгдлийн зардал байгуулснаас гэх зэрэг.
- Өр төлбөр данс 1,517,933.3 мянган төгрөгөөр өссөн нь өмнөх оны татвар, НДШ-ийн өр төлбөрийг бүрэн тусгаагүй байснаас шалтгаалсан байна. Нийт өр төлбөрийн 40.0 хувийг буюу 3,738,152.2 мянган төгрөгийг бэлтгэн нийлүүлэгч байгууллагын, 33.0 хувийг буюу 3,084,713.0 мянган төгрөгийг татварын, 22.9 хувийг буюу 2,141,315.7 мянган төгрөгийг нийгмийн даатгалын шимтгэлийн, 1.7 хувийг буюу 161,737.8 мянган төгрөгийг урт хугацаат буюу хөрөнгө оруулалтын зээлийн, 1.6 хувийг буюу 151,852.8 мянган төгрөгийг цалингийн , 0.5 хувийг буюу 43,294.1 мянган төгрөгийг зээлийн хүүгийн , 0.3 хувийг буюу

28,532.3 мянган төгрөгийг илүү төвлөрүүлсэн дулааны өглөг тус тус эзэлж байна.

3.5. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 болон 20 дугаар зүйлийн 20.3-д заасны дагуу “Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ-ын дарга нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, холбогдох байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

“Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ-ын даргын 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/12 дугаар тушаалаар 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталж, аймгийн Засаг дарга 2023 оны 02 дугаар 01-ний өдөр хянаж, баталгаажуулсан байна.

Тайлант оны нийт орлогыг 8,038,762.0 мянган төгрөгөөр, нийт зардлыг 9,573,390.0 мянган төгрөгөөр тогтоож 1,534,628.0 мянган төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөсөн байна. Хөрөнгө оруулалтын 16 арга хэмжээнд нийт 94,396.0 мянган төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 7,680,555.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 9,124,177.7 мянган төгрөгийн зардал гарган, 1,443,621.8 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

2023 онд дулааны орлого 5,432,399.0 мянган төгрөг, хэрэглээний халуун усны орлого 16,172.7 мянган төгрөг, улсын төсвийн татаас санхүүжилтийн орлого 2,182,043.1 мянган төгрөг, нүүрс борлуулсны орлого 18,149.1 мянган төгрөг, техникийн нөхцөл болон бусад үйлчилгээний орлого 28,363.6 мянган төгрөг, хүү торгуулийн орлого 3,307.9 мянган төгрөг, харилцах дансны хүүгийн орлого 120.5 мянган төгрөгийн зэрэг нийт 7,680,555.9 мянган төгрөгийн орлогыг тус тус бүрдүүлжээ.

Нийт орлогын гүйцэтгэл 7,680,555.9 мянган төгрөг болж 358,206.1 мянган төгрөгөөр буюу 4.5 хувиар тасарсан нь аж ахуйн нэгж, байгууллагын дулааны төлбөрийг эрчим хүчний зохицуулах хорооноос баталсан тарифаар тооцож, төвлөрүүлж чадахгүй байгаагаас голлон шалтгаалсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 9,124,177.7 мянган төгрөг болж төлөвлөснөөс 449,212.3 мянган төгрөг буюу 4.6 хувиар хэмнэгдсэн нь удирдлагын зардлыг 30,627.0 мянган төгрөгөөр, нийт зардлыг 418,585.3 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс шалтгаалсан байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6. Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

“Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ-ын 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу дараах 3 худалдан авах ажиллагааг tender.gov.mn цахим сайтаар нээлттэй зарласан байна. Үүнд:

- 355,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “КЕ 25/14, КВТС 20/150 зуухнуудын сэлбэг материал, насос худалдан авах”,
- 320,900.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Шатахуун нийлүүлэгчийг сонгон шалгаруулах”,
- 39,250.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Мах ханган нийлүүлэгчийг сонгон шалгаруулах”,

Худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг харьцуулалтын болон нээлттэй тендер шалгаруулалтын аргаар сонгон шалгаруулж, гүйцэтгэгчтэй “Худалдах, худалдан авах гэрээ” байгуулан ажилласан байна. Үүнд:

- “Шатахуун нийлүүлэгчийг сонгон шалгаруулах” нээлттэй тендер шалгаруулалтыг 2 удаа зохион байгуулж 2 оролцогч материал ирүүлсэн боловч техникийн тодорхойлолтод тавигдах шаардлагын дагуу өр төлбөрийн үлдэгдэлтэй тул шаардлага хангаагүй гэдэг үндэслэлээр “Шунхлай”петролиум” ХХК-тай гэрээ байгуулан худалдан авах ажиллагааг гүйцэтгэсэн,
- “Мах ханган нийлүүлэгчийг сонгон шалгаруулах” нээлттэй тендер шалгаруулалтыг 2 удаа зохион байгуулсан боловч тендерийн материал ирээгүй тул Ж.Оюундэлгэр, н.Цолмон зэрэг иргэдтэй шууд гэрээ байгуулан худалдан авах ажиллагааг гүйцэтгэсэн,
- “КЕ 25/14, КВТС 20/150 зуухнуудын сэлбэг материал, насос худалдан авах” нээлттэй тендер шалгаруулалтад 2 оролцогч материал ирүүлсэн боловч аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар сэлбэг материалыг нийлүүлэхээр болсон байна.

4. Аудитын тайлан

4.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж, аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн төлбөрийн цахим баримт, татвар, шимтгэлтэй холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу аудитор Ц.Уртнасан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

“Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 165 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 8,654,057.1 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу **86,540.5** мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 01/776 дугаар албан бичгээр Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллах чиглэл хүргүүлсэн байна.

Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

- Хэвлэл захиалга хийгээгүй, сургалтыг цахимаар зохион байгуулсан,
- Ажилчдын утасны зардлын хэмжээг бууруулсан,
- Шинэ жилийн арга хэмжээг хийгээгүй, гарын бэлэг олгоогүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлд тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

“Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ нь тайлант хугацаанд шилэн дансанд мэдээлбэл зохих 157 мэдээллээс 152 мэдээллийг хугацаанд нь, 5 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Үүнд:

- *Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө- 1 дүгээр сард,*
- *Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалт-1 дүгээр сард,*
- *Аудитын дүгнэлт -7 сард*
- *Санхүүгийн тайлан -8 сард*
- *Дараа жилийн зорилтот түвшин-9 дүгээр сард,*

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 124 дүгээр “Санхүүгийн тайланд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд 2023 оны 03 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 7,017.4 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 1,492,889.4 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэн, 154,014.6 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгөгдсөнөөс биелэлтийг аудитаар дахин хянахад бүрэн хэрэгжсэн байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	7,017.4	1	7,017.4	100.0
Албан шаардлага	2	1,492,889.4	2	1,492,889.4	100.0
Зөвлөмж	3	154,014.6	3	154,014.6	100.0
Нийт дүн	6	1,653,921.4	5	1,505,644.3	100.0

4.6. ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

- Тус ААТҮГ нь үйлдвэрлэлийн үр дүнгээр алдагдал хүлээж, өөрөө өөрийгөө санхүүжүүлэн ажиллаж чадахгүй байгаа нь удирдлага, менежментийн үйл ажиллагаатай холбоотой эсэх, шаардлагатай бол бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийх эсэхийг гүйцэтгэлийн аудитаар гүнзгийрүүлэн шалгах нь зүйтэй юм.
- Санхүүгийн тайланд тайлагнагдсан 1,459,594.5 мянган төгрөгийн авлага, 9,349,597.9 мянган төгрөгийн өр төлбөрт дүн шинжилгээ хийж, барагдуулах болон шаардлагатай бол хариуцагч нь тодорхой бус, олон жилийн насжилттай авлагуудыг холбогдох байгууллага, албан тушаалтнаар шийдвэрлүүлж, данс бүртгэлээс хасах талаар үр нөлөө бүхий арга хэмжээ авсан эсэхийг дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай байна.

5. Аудитын илрүүлэлт

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой дараах **42,056.2** мянган төгрөгийн дараах алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- Дулааны төлбөрийн илүү төлөлт 38,183.2 мянган төгрөгийг дансны авлага бууруулж тайлагнасан,
- НӨАТ-ын тайланд 3,873.0 мянган төгрөгийн орлого дутуу тайлагнасан.

Аудитаар нийт **1,267,612.3** мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс **236.0** мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, **1,146,744.5** мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлэн, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх **120,631.8** мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

1. Төлбөр, тооцоог урьдчилан хянан баталгаажуулаагүйн улмаас борлуулалтын нягтлан бодогч О.Энхзаяад 236.0 мянган төгрөгийн цалин илүү тооцож олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “ дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг хянан, баталгаажуулах” гэсэн заалт болон байгууллагын даргын 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн Б/27 дугаар тушаалыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1.Тайлант онд дансны авлагын 38.4 хувь буюу **561,644.1** мянган төгрөгийн, өглөгийн 5.9 хувь буюу **223,532.3** мянган төгрөгийн авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь “*Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Дансны авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж байх албан шаардлага хүргүүлэв.

2. Ор хоногийн зардлын баримтгүйгээр Улаанбаатар болон Дархан-Уул аймагт ажилласан ажилтнуудын томилолтын зардалд **3,362.0** мянган төгрөг олгож, бүртгэл тайланд тусгасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно*”, 13.7 дахь “ *Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх албан шаардлага хүргүүлэх.

3. Боловсруулж, батлуулсан 2023 оны санхүүгийн төлөвлөгөөнд тусгагдсан орлогын төлөвлөгөөг **358,206.1** мянган төгрөгөөр тасалсан байна. Энэ нь Төрийн

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь "Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан **биелэлтийг хангах**" гэсэн заалт болон аймгийн Засаг даргын баталсан 2023 оны "Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг"-г зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Үйлдвэрлэлийн удирдлага, менежментийг сайжруулах, "Үйлдвэрлэл санхүүгийн төлөвлөгөө"-г бодитоор төлөвлөх замаар батлагдсан орлогын төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага хүргүүлэх.

5.3 Зөвлөмж

Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд 119,211.6 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна. Энэ нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь "Зардал бодитой гарсан бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан баримт болон холбогдох бүртгэлээр баталгаажсан байх", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм..." гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Төлбөрийн цахим баримтыг үндэслэж, ажил гүйлгээг гүйцэтгэж байх.

Татвартай холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын Эрчим хүчний тэргүүний ажилтны шагналын 14,202.0 мянган төгрөгөөс 1,420.2 мянган төгрөгийн татвар суутгаагүй нь татварын хяналт шалгалтаар акт, өр төлбөр үүсэж болзошгүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх "цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого", 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу тухайн жилийн орлогыг тодорхойлоход 0-120 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 10 хувиар татвар ногдуулна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: ХХОАТ-ыг хуулийн дагуу тогтоож, суутган тооцож байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5² дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ
Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Залруулсан		Залруулаагүй		Зөвлөмж	
	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Залруулсан		Залруулаагүй		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Авлага бууруулж тайлагнасан	1	38,183.2			1	38,183.2	1	38,183.2				
НӨАТ-ын тайланд орлого дутуу тайлагнасан	1	3,873.0			1	3,873.0	1	3,873.0				
Нийт дүн	2	42,056.2			2	42,056.2	2	42,056.2				

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөр-ийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлаг а тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Нийт зөрчил		Төлбөр-ийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлаг а тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалин илүү олгосон	1	236.0	1	236.0								
Авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй	1	785,176.4			1	785,176.4						
Анхан шатны бүрдэл дутуу баримтаар томилолтын зардал олгосон	1	3,362.0			1	3,362.0						
Баталсан орлогын төлөвлөгөөг тасалсан	1	358,206.1			1	358,206.1						
Төлбөрийн цахим баримтаар баталгаажуулаагүй худалдан авалт хийсэн	1	119,211.6					1	119,211.6				
Шагнал урамшууллаас татвар суутгаагүй	1	1,420.2					1	1,420.2				

/мянган төгрөгөөр/

Нийт дүн	6	1,267,612.3	1	236.0	3	1,146,744.5	2	120,631.8		
----------	---	-------------	---	-------	---	-------------	---	-----------	--	--

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил						Үүнээс					
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
5 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн	1										1	
Дүн	1										1	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
Дүн												
Нийт дүн	1										1	